

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12.	Шилэн дансны мэдээлэл	10
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	14
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮДАГ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
МЭЭСБУЛ	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА
Д.ТҮМЭНДЭМБЭРЭЛ ТАНАА

2020.03.24 № 06/322
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Түмэндэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа хэрэгжүүлэв.

Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/281 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангаж, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино.

Дээрх тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд стратегийн 11 зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Байгууллагын Төрийн захиргаа, санхүү, удирдлагын газрын санхүүгийн дотоод аудитор нь ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-ын мэргэжилтнүүдтэй харьяа 4 газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр зөвлөмж өгч ажилласан байна.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Гүүк софт ХХК-ийн Динамик программ хангамж ашигладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мал эмнэлгийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 31,559.5 сая төгрөгөөс тооцон 315.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 529.3 сая төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь болон хувь хэмжээг өөрчлөөгүй ч санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүн өссөнтэй холбоотой болно.

2.8. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 25 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүгд аудитад хамрагдаж, МЭЭГ-ыг түүврээр аудит хийсэн.

Аудитад хамрагдсан харьяа 23 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Говь-Алтай аймгийн МЭГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1 алдааг аудитын явцад залруулж, харьяа байгууллагуудын аудитаар нийт 430.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7.8 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 157.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 15 албан шаардлага өгч, 264.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 46 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн шууд захирагчийн тайлангийн загвараар гаргасан нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1.1 сая, эцсийн үлдэгдэл 0.3 сая төгрөг болж 0.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.1	0.3	0.2
Банкинд байгаа бэлэн мөнгө	1.0		-1.0
Дүн	1.1	0.3	-0.8

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь Баян-Өлгий аймгийн МЭГ болон Нийслэлийн МЭГ-ын мөнгөн хөрөнгө байна.

Аудитын илрүүлэлт:

Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудын МЭГ, МЭЭГ-ын аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой 48.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Анхан шатны баримтгүй, норматив илүү тооцсон, зэрэг дэвийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал үндэслэлгүй олгосон;

- Албан томилолтоор ажилласан ажилтнуудад хоол унааны мөнгө давхардуулж олгосон;
- Батлагдсан норм баримталж ажиллаагүйгээс шатахуун илүү зарцуулсан, хуримтлалыг суутгасан дүнгээс илүү шилжүүлсэн;
- Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон;
- Бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардлаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зарцуулсан.

2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 194.3 сая, эцсийн үлдэгдэл 3,704.6 сая төгрөг болж, 3,510.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.9	4.4	2.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	13.6	12.7	-0.9
Татаас, санхүүжилтийн авлага	175.3	3,642.7	3,467.4
Бусад авлага	3.5	44.7	41.2
Дүн	194.3	3,704.6	3,510.3

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Татаас санхүүжилтийн авлага нь зардлын хэмнэлтээс татан төвлөрүүлсэн 3,000.0 сая, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн 553.8 сая төгрөгийг Сангийн яамнаас авах авлагаар тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Булган, Завхан аймгийн МЭГ, УМЭАЦТЛ-ийн аудитаар авлага үүсгэсэн, авлага барагдуулах тухай өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй зэрэг 4.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс 4.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0	4.8	4.8
Дүн	0	4.8	4.8

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөговь аймгийн МЭГ нь интернетийн төлбөр 4.8 сая төгрөгийг Говийн анир ХХК-д илүү шилжүүлж урьдчилж гарсан зардалд бүртгэснийг аудитаар зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн байна.

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 5,123.1 сая, эцсийн үлдэгдэл 12,567.7 сая төгрөг болж, 7,444.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	652.7	1,915.1	1,262.4
Эм боох материал	1,154.9	5,563.2	4,408.3
Бичиг хэргийн материал	15.6	86.7	71.1
Аж ахуйн материал	288.7	846.8	558.1
Сэлбэг хэрэгсэл	10.3	32.1	21.8

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Түлш, шатах тослох материал	6.6	61.4	54.8
Барилгын засварын материал		33.3	33.3
Хүнсний материал		0.1	0.1
Бусад хангамжийн материал	2,988.4	3,988.8	1,000.4
Мал амьтад	5.9	40.2	34.4
Дүн	5,123.1	12,567.7	7,444.6

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал 39,614.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 32,170.3 сая төгрөгөөр хасагдсанаас худалдаж авсан 16,661.2 сая, хандиваар 1,698.3 сая, шилжүүлж авсан 21,255.3 сая төгрөгийн бараа материал байна.

Аудитын илрүүлэлт:

Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорноговь, Төв аймгуудын болон Нийслэлийн МЭГ-ын аудитаар бараа материалтай холбоотой нийт 196.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн;
- 2 ширхэг орны үнийг урсгал засварын зардлаас зарцуулсан;
- Бараа материалын зарлагын баримтын гарын үсэг дутуу;
- Худалдан авсан бараа материалыг шууд зарлагадсан;
- Малчдаас авсан вакцины үнийг хувийн дансанд төвлөрүүлсэн;
- Хөрөнгө, бараа материал шууд худалдан авсан;
- Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримтад и-баримт хавсаргаагүй;
- Түлш, халаалтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлэлгүй нүүрс нөөцөлсөн, нормын хувцасны төсвөөс биеийн тамирын хувцас худалдан авсан.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,261.5 сая, эцсийн үлдэгдэл 18,443.9 сая төгрөг болж, 9,182.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	8,552.4	16,611.9	8,059.5
Барилга, байгууламж, орон сууц	3,802.5	7,420.2	3,617.7
Хуримтлагдсан элэгдэл	-2.8	-461.7	458.9
Авто-тээврийн хэрэгсэл	802.4	5,516.3	4,713.9
Хуримтлагдсан элэгдэл	-632.2	-4,292.2	3,660.0
Машин тоног төхөөрөмж	1,384.2	10,869.8	9,485.2
Хуримтлагдсан элэгдэл	-942.3	-6,709.4	5,766.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,015.4	1,653.7	638.3
Хуримтлагдсан элэгдэл	-620.7	-956.9	336.2
Бусад үндсэн хөрөнгө	6,326.4	6,868.1	541.7
Хуримтлагдсан элэгдэл	-3,655.8	-4,371.0	751.2
Дуусаагүй барилга	1,075.0	1,075.0	-
Биет бус хөрөнгө	709.1	1,832.2	1,123.1
Програм хангамж	529.6	79.2	-450.4
Хуримтлагдсан элэгдэл	527.3	14.7	-512.6
Бусад биет бус хөрөнгө	708.6	1,770.7	1,062.1
Хуримтлагдсан элэгдэл	-1.8	-3.0	1.2
Дүн	9,261.5	18,444.1	9,182.6

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө 20,253.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс худалдаж авсан 1,139.2 сая, хандиваар 973.1 сая, шилжүүлж авсан 18,141.5 сая төгрөгийн хөрөнгө байна. ТӨБЗГ-ын 2019

оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-1/4425 дугаар албан бичгээр 645.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас хассанаас акталсан 302.8 сая, балансаас балансад шилжүүлсэн 342.5 сая төгрөгийн хөрөнгө байна.

Дуусаагүй барилга дансанд УМЭАЦТЛ-ийн оффисийн барилгыг улсын комисс хүлээж аваагүй байгаа шалтгаанаар 1,075.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Булган аймаг, Нийслэлийн МЭГ болон УМЭАЦТЛ-ийн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 62.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн;
- Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- Тендерийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 11.7 сая, эцсийн үлдэгдэл 19.4 сая төгрөг болж, 7.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.1	8.1	8.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг		0.7	0.7
Байгууллагад төлөх өглөг	11.0	9.7	-1.3
Хувь хүмүүст төлөх өглөг	0.1	0.9	0.8
Урьдчилж орсон орлого	0.5		-0.5
Дүн	11.7	19.4	7.7

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 10.7 сая төгрөг нь МЭЭГ болон Нийслэлийн МЭГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Төв аймгийн МЭГ-ын аудитаар өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 62.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 14,568.3 сая, эцсийн үлдэгдэл 34,701.9 сая төгрөг болж, 20,133.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	8,047.9	9,281.8	1,233.9
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,233.8		-1,233.9
Хуримтлагдсан үр дүн	3,226.2	21,278.8	18,052.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,060.4	4,141.5	2,081.1
Дүн	14,568.3	34,702.1	20,133.8

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолын дагуу МЭЭСБУЛ нь тайлант онд улсын төсвийн байгууллага болсны улмаас 1,233.9 сая төгрөгийн өмчийг Засгийн газрын хувь оролцоо дансанд шилжүүлж бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Говьсүмбэр аймгийн МЭГ болон МЭЕГ-ын аудитаар хуримтлагдсан үр дүнд нөлөөлөх 50.1 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ОХУ болон Энэтхэг улстай малын гоц халдварт шүлхий, мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин худалдан авах гэрээний төлбөрийг хийхдээ валютын ханшийн зөрүүгийн алдагдал бүртгээгүй;
- Орлогын төлөвлөгөө тасарсан;
- Кассын орлогыг төрийн санд хоцроож тушаасан.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 51,281.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 51,007.0 сая төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд, 274.1 сая төгрөгийг урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 50,897.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 383.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 50,133.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 520.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 47,653.8 сая төгрөг буюу 90.0 хувьтай байгаа нь улсын төсвийн санхүүжилтээс 3,000.0 сая төгрөгийг татан төвлөрүүлж Сангийн яамнаас авах авлагаар тайлагнасангай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар Швейцарийн хөгжлийн агентлаг Ногоон алт малын эрүүл мэндийн төслөөс нийт 18,144.1 сая төгрөг төвлөрүүлж зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл нийт 553.8 сая төгрөгийг татан төвлөрүүлж авлагаар тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дижитал сервис ХХК-тай 2019 оны 6 дугаар сард мал эмнэлгийн холбогдолтой хууль, дүрэм, журам, стандарт, заавруудын эмхтгэл хэвлүүлэх гэрээ байгуулж 27.3 сая төгрөг шилжүүлсэн боловч тайлант хугацаанд хүлээж аваагүй авлагаар бүртгэснийг дараагийн аудитаар хянаж үзнэ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Мал эмнэлгийн ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус газар нь жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд 2 төрлийн мэдээллийг хугацаанд нь, 3 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

МЗЭГ-ын өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмж, 1 албан шаардлагын биелэлт 100 хувь байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мал эмнэлгийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаар

3.1.1 Илрүүлэлт

Мал эмнэлгийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагааны зардалд 787.6 сая төгрөг батлагдсанаас бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардлаас 17.5 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд гүйлгэн зарцуулсан байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн төлөвлөлт бодитой бус байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

3.2 Худалдан авалтын гэрээний төлбөрийн талаар

3.2.1 Илрүүлэлт

ОХУ болон Энэтхэг улстай малын гоц халдварт шүлхий, мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин худалдан авах 4.302.0 мянган ам.долларын гэрээний төлбөрийг хийхдээ валютын ханшийн зөрүүгийн алдагдал 48.4 сая төгрөг бүртгээгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн үр дүн алдаатай илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

3.3 Засварын зардлын талаар

3.3.1 Илрүүлэлт

Байгууллагын автомашины засвар үйлчилгээнд 11.6 сая төгрөг зарцуулсны 1.8 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас гаргасан байна.

3.3.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 09 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,318,567.6	16,277,430.4
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,125.2	260.5
АВЛАГА	194,299.0	3,704,617.8
УРЬДЧИЛГАА	0.0	4,866.8
БАРАА МАТЕРИАЛ	5,123,143.3	12,567,685.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,261,511.4	18,444,093.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,261,511.4	18,444,147.8
Биет хөрөнгө	8,552,453.6	16,611,918.8
Биет бус хөрөнгө	709,057.7	1,832,229.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,580,078.9	34,721,578.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,737.2	19,464.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,737.2	19,464.2
Өглөг	11,273.8	19,464.2
Урьдчилж орсон орлого	463.4	0.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,568,341.7	34,702,114.0
Засгийн газрын хувь оролцоо	14,568,341.7	34,702,114.0
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,047,949.5	9,281,790.5
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,233,841.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	3,226,182.1	21,278,846.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,060,369.1	4,141,476.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,580,078.9	34,721,578.2

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,936,354.0	73,067,065.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,287,516.6	15,787,896.8
Нийтлэг татварын бус орлого	4,287,516.6	15,787,896.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,648,837.4	57,279,168.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	29,420,095.0	52,933,293.3
УРСГАЛ ЗАРДАЛ	29,420,095.0	52,933,293.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,297,571.6	51,956,237.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,289,475.4	4,870,222.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,844.3	654,734.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,593.6	520,400.5
Хангамж, бараа материалын зардал	154,345.6	1,091,151.9
Нормативт зардал	16,039,067.3	18,875,585.3
Эд хогшил, урсгал засварын зардал	221,539.0	563,740.4

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Томилолт, зочны зардал	317,012.5	286,226.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,053,848.9	19,152,764.7
Бараа үйлчилгээний бусад зардал	920,845.0	5,941,410.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	122,523.4	977,055.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,516,258.9	20,133,772.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	166,315.8	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,349,943.1	20,133,772.3

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,770,534.8	0.0	8,770,534.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	100,500.0	0.0	100,500.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,871,034.8	0.0	8,871,034.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,385,927.8	0.0	1,385,927.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	961,436.1	0.0	961,436.1
Тайлант үеийн үр дүн	3,349,943.1	0.0	3,349,943.1
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,568,341.7	0.0	14,568,341.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,081,107.8	0.0	-2,081,107.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,487,233.9	0.0	12,487,233.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,081,107.8	0.0	2,081,107.8
Тайлант үеийн үр дүн	20,133,717.7	0.0	20,133,772.3
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,702,059.4	0.0	34,702,114.0

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	29,112,606.7	58,038,839.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	463,769.4	520,489.7
Нийтлэг татварын бус орлого	463,769.4	520,489.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,648,837.4	57,518,349.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,056,402.2	56,900,520.7
УРСГАЛ ЗАРДАЛ	29,056,402.2	56,900,520.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,760,619.9	52,279,313.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,290,255.9	3,585,509.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,844.3	452,324.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,846.0	539,607.4

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хангамж, бараа материалын зардал	154,720.7	979,783.8
Нормативт зардал	16,400,072.2	13,411,010.5
Эд хогшил, урсгал засварын зардал	289,603.6	908,244.8
Томилолт, зочны зардал	314,407.3	283,228.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,931,804.4	27,857,212.1
Бараа үйлчилгээний бусад зардал	83,065.4	4,262,393.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	295,782.4	4,621,206.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	56,204.5	1,138,318.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	55,079.2	1,139,183.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,079.2	1,139,183.7
Дотоод эх үүсвэрээр	55,079.2	1,139,183.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-55,079.2	-1,139,183.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,125.2	-864.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	1,125.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,125.2	260.5

4.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,281,115.6	47,653,857.3	3,627,258.3	92.9
УРСГАЛ ЗАРДАЛ	51,281,115.6	47,653,857.3	3,627,258.3	92.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,007,031.9	47,406,758.4	3,600,273.5	92.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,375,333.8	3,366,051.2	9,282.6	99.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	425,760.2	421,657.1	4,103.1	99.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	564,152.3	528,468.5	35,683.8	93.7
Хангамж, бараа материалын зардал	861,982.5	839,078.7	22,903.8	97.3
Нормативт зардал	13,151,124.1	13,101,433.8	49,690.3	99.6
Эд хогшил, урсгал засварын зардал	1,651,500.0	1,630,819.4	20,680.6	98.7
Томилолт, зочны зардал	110,611.3	108,100.3	2,511.0	97.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,501,358.0	27,051,463.5	3,449,894.5	88.7
Бараа үйлчилгээний бусад зардал	365,209.7	359,685.9	5,523.8	98.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	274,083.7	247,098.8	26,984.9	90.2
Бусад урсгал шилжүүлэг	274,083.7	247,098.8	26,984.9	90.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51,281,115.6	47,653,857.3	3,627,258.3	92.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,897,809.7	47,133,367.6	3,764,442.1	92.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	383,305.9	520,489.7	-137,183.8	135.8
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	25	25		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	345	488		

4.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,141,914.4
УРСГАЛ ЗАРДАЛ	18,141,914.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,321,577.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,457.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,667.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,138.9
Хангамж, бараа материалын зардал	195,283.6
Нормативт зардал	316,513.7
Эд хогшил, урсгал засварын зардал	101,525.2
Томилолт, зочны зардал	240,656.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,240,837.6
Бараа үйлчилгээний бусад зардал	3,965,497.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	820,337.3
Бусад урсгал шилжүүлэг	20,197.1
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	800,140.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,142,174.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	18,142,174.9
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	260.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	260.5

5. Хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Мал эмнэлгийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	
2020/03/24		Аудитын код:	САГ-2020/18/СТА-ТТ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Мал эмнэлгийн ерөнхий газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6
1	Бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардлаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд гүйлгэн зарцуулсан	17.5	Зөвлөмж өгөх		Дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Түмэндэм бэрэл Л.Гандолгор
2	Малын гоц халдварт шүлхий, мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин худалдан авах гэрээний төлбөрийг хийхдээ валютын ханшийн зөрүү бүртгээгүй	48.4	Зөвлөмж өгөх			
3	Автомашин засвар үйлчилгээнд 11.6 сая төгрөг зарцуулсаны 1.8 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас гаргасан	11.6	Зөвлөмж өгөх			
Нийт		77.5				

